

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,

БАЙГАЛЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

А.ЭНХБАТ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЯЛГУУН ИНТЕРНЭШНЛ” ХХК-  
ИЙН СӨГДӨХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ИЛ УУРХАЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/Тусгай зөвшөөрлийн дугаар MV-002425/

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН:

Боловсруулсан:

БО-ны мэргэжилтэн

Э.Пүрэвдорж

ХАБЭА-н ажилтан

П.Батдорж

Улаанбаатар хот  
2024он

## ГАРЧИГ

1.2Төслийн байршил.....	6
1.3Төслийн хүчин чадал, технологи.....	7
1.3.1.Төслийн хүчин чадал.....	7
1.3.2. Олборлолтын технологи.....	7
<b>ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	<b>9</b>
2.1.Болзошгүй нөлөөллийн тодорхойлолт.....	9
2.2.Болзошгүй нөлөөллийн тоон үнэлгээний нэгтгэл.....	11
2.3.Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим.....	16
2.4.Төслийг хэрэгжүүлэхэд бэлтгэх үеийн гол нөлөөлөл:.....	17
2.5.Төсөл хэрэгжилтийн үеийн байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл.....	18
<b>ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>19</b>
3.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
3.2.Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн зардал.....	277
3.3. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	27
3.4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө.....	28
3.5.Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	28
3.5.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	30
3.7.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	31
3.8.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	31
3.9.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	34
3.10 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	35

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сөгдөхийн шохойн чулууны ордын газар зүйн солбицол.....	7
Хүснэгт 2. Ил уурхайн процессын механикжуулалт .....	7
Хүснэгт 3. Ажлын талбайн хамгийн бага өргөн .....	8
Хүснэгт 4. Леопольдын матрицын тоон үнэлгээ буюу нөлөөллийн эрчим .....	11
Хүснэгт 5. Жингийн коэффициентийн утга.....	12
Хүснэгт 6. Шеноны энтропигийн утга .....	13
Хүснэгт 7. Нөлөөллийн чухал байдал .....	13
Хүснэгт 8. Байесын критер.....	14
Хүснэгт 9. Лейпольдын матриц .....	15
Хүснэгт 10. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа.....	17
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгтгэл .....	19
Хүснэгт 12. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..	21
Хүснэгт 13. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
Хүснэгт 14. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг .....	
бууруулах арга хэмжээнүүд.....	25
Хүснэгт 15. Биологийн төрөл зүйлд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд.....	26
Хүснэгт 16.. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	27
Хүснэгт 17. Түүх соёлийн өвийг хамгаалах төлөвлөгөө.....	28
Хүснэгт 18. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	29
Хүснэгт 19. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	30
Хүснэгт 20. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь.....	31
Хүснэгт 21. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	34
Хүснэгт 22. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	
Хүснэгт 17. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	31
Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	38
Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь .....	32
Хүснэгт 20. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь .....	35

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Шохойн чулууны орд газар орчмын сансрын зураг .....	6
Зураг 2. Шохойн чулуу боловсруулах технологийн схем .....	9
Зураг 3. Мониторингийн цэгийн байршил .....	33

### НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамраалгүй мэдээллийг “*хамааралгүй*” гэж бөглөнө.
- 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

Д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Ялгуун интернэшнл” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011107057
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа, ашигт малтмал олборлолт
	4. Аж ахуйн нэгжийн харьяачаллын хаяг	Дорноговь аймгийн Өргөн сумын 1 дүгээр баг
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Захирал З.Нацагдорж Утас:99118991,
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Э.Пүрэвдорж 95559555
1.2	1. Төслийн нэр	Шохойн чулууны орд
	2. Төслийн харьяаллын байршил	Дорноговь аймгийн Өргөн орд
	3. Төслийн ангилал <ul style="list-style-type: none"> <li>a. Нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт</li> <li>b. ил уурхай, далд уурхай, шороон орд</li> <li>c. баяжуулах үйлдвэр</li> </ul>	Шохойн чулууны ил уурхай
	4. Төсөл эхэлсэн огноо	2017он
	5. Төсөл хэрэгжих хугацаа	2017-2027 он
	6. Уурхайн хаалт эхлэх огноо	2027он
	7. Хаалтын дараах зориулалт	Бэлчээр ашиглалт
	8. ТЭЗҮ баталсан огноо	2017 оны 05 дугаар сарын 22-ны өдөр
	9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	93.4 мян.тн
	10. Ажилчдын тоо	22 хүн
	11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	Хөрс хуулалт байхгүй. 206.13 мян.тн шохойн чулуу олборлож /30-60 мм-ийн/ 104.26 мян.т. шохойн чулуу борлуулна.
	12. Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц <ul style="list-style-type: none"> <li>• замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл,</li> <li>• шатахуун агуулахын агууламжийн хэмжээ</li> <li>• тэслэх, дэлбэрэх бодисын үйдвэрийн хүчин чадал гэх мэт</li> </ul>	Уурхайн ажилчдын байрнаас уурхайн захиргаа орох зам -1.6 км Уурхайн захиргааны байрнаас уурхайн тоног төхөөрөмжүүд хүрэх зам-0.9 км Уурхайгаас бутлуур хүрэх зам-0.3 км Уурхайгаас ШТС хүрэх зам -0.9 км Тэсэлгээний байгууламж байхгүй.

**Төсөл хэрэгжүүлэх чиглэлээр олгогддог тусгай зөвшөөрөл, дүгнэлт, лавлагааны товч мэдээлэл**

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлтийг баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтийн 2.1.9,2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах баганад хавсралтын нэрийг оруулах.

Д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	- MV-002425 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай - Ашигалтын 7 жил - 28.9га
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа	- Химийн бодис ашиглахгүй
	3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтийн газрын тодорхойлолт	-
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	-
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	- 2023-06-08, №13/3509 - Байгаль орчин аялал жуулчлалын яам
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан төлөвлөгөөний огноо	- 2024-03-23 - Байгаль орчин аялал жуулчлалын яам
	7. Ус ашигалатын дүгнэлтийн огноо	-
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо	- 2024он
	9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.,11 дэх маягтыг хавсаргах	- Геологийн болон үйлдвэрлэлийн нөөц, маягт 2.1 - Цахилгаан хангамж, маягт 6.1 - Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, маягт 7 - Олборлолтын техник тоног төхөөрөмжийн жагсаалт, маягт 8 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, маягт 12 - Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг судлах, хамгаалах, маягт 12 - Байгаль орчны нөхөн сэргээлт, маягт 10 - Уурхайн ус хангамж, маягт 6.2 - Уурхайн өрөмдлөг тэсэлгээний ажил, маягт 9 - Баяжуулалтын технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, маягт 4.1


		<ul style="list-style-type: none"> <li>- Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд, маягт 3.1</li> <li>- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөв, маягт 1.1</li> <li>- Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, маягт 16</li> <li>- Улс, роон нутгийн төсөвт оруулах орлого, маягт 15</li> <li>- Нийт зардлын задаргаа, маягт 16</li> </ul>
	<p>10. ТХГН-ын тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашиг малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хийлийн заагтай давхцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах</p>	<p>2024 оны 2 сарын 08-ны лавлагаа мэдээллийг хавсаргав.</p>
	<p>11. Тухайн жилд баримтлах стандартын дугаар</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний</li> <li>• Олон улсын</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- MNS 4586:2015 Усан орчны чанарын үзүүлэлт, ерөнхий шаардлага</li> <li>- MNS 900:2005 Ундны усны чанарын стандарт</li> <li>- MNS 2573:1978 Байгаль орчныг хамгаалах. Усны чанарын үзүүлэлт</li> <li>- MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.</li> <li>- MNS4890:2000 ХААЭА. Ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага.</li> <li>- MNS 3383:1982 Агаар мэндэл. Бохирдуулагчийн эх үүсвэрийг тодорхойлох</li> <li>- MNS 12.1.009:1985 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Дуу чимээ.Барилга байгууламжийн үеийн дуу чимээний зөвшөөргдөх түвшин.</li> <li>- MNS 12.1.06:1988 Хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартын систем</li> <li>- MNS12.4.005:1985 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа.Дуу чимээнээс хамгаалах багажийг ашиглах арга</li> <li>- MNS 4601:2011 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүн. Техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо</li> <li>- MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага.</li> <li>- MNS 3297:1991 Хөрс. Хот суурин газрын эрүүл ахуйн үзүүлэлтүүд.</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.</li> <li>- MNS 2305:2011 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам.</li> <li>- MNSISO 5667-10:2001 Байгаль орчин. Усны чанар. Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж</li> </ul>
--	--	---

### 1.2 Төслийн байршил

Сөгдөхийн шохойн чулууны орд нь Дорноговь аймгийн төв Сайшандаас зүүн урагш 55км-т, Дорноговь аймгийн Өргөн сумаас баруун урагш 30км-т оршино. Судалгааны талбай нь Улаанбаатар-Замын Үүдийн төв магистраль авто замаас баруун урагш 8 км шороон замаар холбогдсон. Зам харилцаа, дэд бүтцийн хувьд сайн хөгжсөн орон нутагт хамаарагдах бөгөөд Улаанбаатар хотоос Замын үүд хүртэл асфальтан замтай.

- Талбайн хэмжээ: 28.9 га (МУ-002425 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай 29 га, үйлдвэрийн талбай 2.5 га)
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-49-125



Зураг 1. Шохойн чулууны орд газар орчмын сансрын зураг

*Хүснэгт 1. Сөгдөхийн шохойн чулууны ордын газар зүйн солбицол*

№	Уртраг	Өргөрөг
1	110° 29' 40.85"	44° 36'58.57"
2	110° 29' 15.86"	44° 36'58.57"
3	110° 29' 15.86"	44° 37'15.57"
4	110° 29' 40.85"	44° 37'15.57"

**1.3 Төслийн хүчин чадал, технологи**

**1.3.1.Төслийн хүчин чадал**

Тус төслөөр жилд 210000 тн шохойн чулуу боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг түшиглэж 106218 тн боловсруулсан шохой жилд гаргах юм. Гэвч зах зээлийн эрэлтээс хамаарч 2024 онд уурхайгаас 210 мян.тн шохойн чулуу олборлож /30-60 мм-ийн/ 75 мян.т. шохойн чулууг боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ.

**1.3.2. Олборлолтын технологи**

Сөгдөхийн шохойн чулууны ордын тогтоц уул техникийн нөхцөлөөс хамааруулан ил уурхайн аргаар олборлох нь зүйтэй гэж үзсэн бөгөөд ил уурхайн хүрээ хязгаарыг үйлдвэрийн кондиционшаардлагыг хангасан В-I зэрэглэлийн нөөцөд тулгуурлан Ил уурхайн эцсийн хүрээ нь дунджаар 450 м урт, 260 м өргөн, газрын гадаргуугаас 80-95 м гүнтэй байна. Төслийн хугацаанд үүсэх ил уурхайн хүрээ нь дунджаар 219 м урт, 222.1 м өргөн, газрын гадаргуугаас 15-20 м гүнтэй байна.

Овоолго болон, шохойн чулууны тээвэрлэлтээс хамааран траншейн байршил хойноос урагш чиглэсэн байна.

Ил уурхайн ашиглалтын технологи: Ордын тогтоц болон уул техникийн нөхцөлөөс нь хамааруулан уурхайд тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын систем сонгосон ба үүнд шаардлагатай дараах механикжуулалтын бүтэц тохиромжтой гэж үзэв.

*Хүснэгт 2. Ил уурхайн процессын механикжуулалт*

Ажил	Процессууд (тоног төхөөрөмж)		
	Шимт хөрс хуулалт	Ухаж түрэх Утгуурт ачигч	Ачиж тээвэрлэх Экскаватор→автосамовал
Хөрс хуулалт	Экскавац	Тээвэрлэлт	Овоолго
	Экскаватор	Автосамосвал	Утгуурт ачигч
Хүдэр олборлолт	Экскавац	Тээвэрлэлт	Овоолго
	Экскаватор	Автосамосвал	Утгуурт ачигч

Ашиглалтын элемент үзүүлэлт:

**Доголын өндөр.** Хүдрийн хаягдал бохирдлыг бага байлгах, уурхайн жилийн хүчин чадал, ажиллах тоног төхөөрөмжүүдийн техникийн үзүүлэлт, хөрс болон шохойн чулууны физик механикийн шинж чанар зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн ажлын доголын өндрийг  $H_d=5$  м байхаар тооцов. Доголын өндөр бага байснаар шохойн чулуу хөрсний чулуулгийн зааг орчимд үүсэх хаягдал болон бохирдлын хэмжээ багасах нөхцөл бүрдэнэ.

**Ажлын бус доголын өндөр.** Ажлын догол нь ажлын бус бүсэд шилжихэд ажлын хоёр доголыг нэгтгэн хурааж ажлын бус 10м-ийн өндөртэй догол үүсгэнэ.

**Ажлын доголын хажуугийн өнцөг.** Ажлын доголын хажуугийн өнцөг нь чулуулгийн шинж чанарын нөхцөлөөр  $\alpha_d=50^0-60^0$  байна. Энэхүү хэмжээ төсөл зохиомжид мөрдлөг болгодог нөхцөлтэй зөрчилдөхгүй ( $f=7-8$  бол  $\alpha_d=40^0-60^0$ ).

**Ажлын талбайн өргөн.** Уурхайн ажлын догол дээрх ажлын талбайн зөвшөөрөгдөх хамгийн бага өргөн нь автосамосволгоцоо хэлбэрийн эргэлттэй хөдөлгөөний үед  $B_{atmin}=12$ м байна.



**Фронтын урт.** Доголын фронтын урт нь тухайн доголын ерөнхий хэмжээнээс (уртаас) хамаарна. Доод түвшингүүдийндоголлуудад фронтын урт багасна. Урт нь ордын хувьд  $40 \leq L_f \leq 100$  м байна.

**Ил уурхайн ёроолын өргөн.** Уурхайн ёроолын өргөн ажиллаж байгаа техникийн аюулгүй нөхцөлөөр тодорхойлогдоно. Уурхайн ёроолд автосамосвал нь гогцоо хэлбэрийн схемээр маневрлах ба экскаватор нь ухаж ачих ачилт хийнэ. Иймд ил уурхайн ёроолын хамгийн бага өргөн (ажлын талбайн хамгийн бага өргөн) 18 м-ээс багагүй байна.

$$\text{Ажлын талбайн хамгийн бага өргөн} = 6.0 * 2 + 3.1 + 1.8 + 1.8 = 17.9 \approx 18 \text{ м}$$

Хүснэгт 3. Ажлын талбайн хамгийн бага өргөн

Автотээврийнхэрэгслийн дотоод эргэлтийн радиус, м	6
Автосамосвалынөргөн, м (25 тндаацтай)	3.1
Аюулгүйн зай, м	1.8
Ажлын талбайн хамгийн бага өргөн, м	17.9

#### Төлөвлөлтийн үзүүлэлт

Шохойн чулууг боловсруулах технологийн горимыг туршилтууд, шинжилгээний үр дүнг үндэслэн шохойн идэвх нь  $1000^\circ\text{C}$  температурт шатаахад 81.87%, тунах хугацаа нь 5 минут, туналтын температур  $58^\circ\text{C}$  байж “MNS- 347-2002” стандартын шаардлага хангасан I, II зэргийн шохой гарган авах боломжтой байна. Эндээс шохой боловсруулах процессын хувилбарыг сонголоо. Уулын баяжуулах үйлдвэрлэлд урвалж бодисоор хэрэглэх металлургийн шохойн техникийн шаардлага / MNS- 347-2002 стандарт / нь:

- Ширхэгийн хамгийн том хэмжээ 60 мм-ээс хэтрэхгүй
- Тунах хугацаа нь 15 минутаас удаангүй кальцийн шохой хэрэглэнэ.

Шохой боловсруулах технологийн үндсэн процесс нь шохойн чулууг шатааж нүүрсхүчлийн давхар ислийг ангижруулах урвал юм. Үүнд:




Энэ урвал нь чулууны нягт, хольцын найрлага, зуухны төрөл зэрэг хүчин зүйлүүдээс хамааран температур, даралтын хэмжээг хэрхэн сонгосноос хамаарна.

Онолын хувьд  $600^\circ\text{C}$ -ээс дээш температурт нүүрсхүчлийн кальци задарч эхэлдэг бөгөөд хамгийн тохиромжтой температур нь  $900^\circ\text{C}$  гэж үздэг. Харин ихэнх тохиолдолд үйлдвэрлэлийн нөхцөлд шатаах температурыг  $1100-1200^\circ\text{C}$ -ийг дунджаар / 1100 ккал/ сонгодог байна.

Иймээс технологийн туршилтын дүнг үндэслэн тус ордын шохойн идэвхнь ( $\text{CaCO}_3$ ) нь  $1000^\circ\text{C}$  температурт шатаахад 81.87%, тунах хугацаа нь 5 минут байгааг харгалзан шатаах зуухны горимыг сонголоо.

Зураг 2. Шохойн чулуу боловсруулах технологийн схем



## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1. Болзошгүй нөлөөллийн тодорхойлолт

“Шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах” төслийн баримт бичигт туссан гол зорилго, техник, технологи, эдийн засгийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогийг дээр тодорхойлсон бөгөөд үүнд үндэслэн давхцуулан зураглах арга, Магадлан жагсаах аргыг ашиглан байгаль орчны шинжилгээ хийж, гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эх үүсвэрийг тодорхойлов.

Тус төслийн цаг хугацааны хамрах хүрээ нь жил бүр дулааны улиралд 210 хоног ажиллах бөгөөд нийт 71 жилийн хугацаанд олборлолтын үйл ажиллагаа явагдана. Орон зайн хамрах хүрээ нь шууд болон шууд бус нөлөөллийн бүсээр тодорхойлогдоно. Шууд нөлөөллийн бүс нь 28.9 га талбай бөгөөд энэ орон зайн хүрээнд тус уурхайн олборлолтын үйл ажиллагаа төлөвлөгдсөн байна.

Уг төслийн нөлөөллийн бүсийг тогтоохдоо нэг талаас төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин үзүүлэх нөлөөллийн газарзүйн тархалт хамгийн их байх орон зайн хүрээг, нөгөө талаас байгаль орчны суурь нөхцөлийн хувьд төслийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэх хүчин зүйлийн /үерийн аюул, газар хөдлөлт, хөрсний гулсалт, нуралт гэх мэт/ тархалтын хүрээг тус тус үндэслэв.

Лицензийн талбайн нь ерөнхийдөө толгодорхог гадаргатай. Ийм учир шингэн хэлбэрийн эсвэл хатуу хог хаягдал орчинд ялгарах үед ялгаралтын орон зайн хамрах хүрээ нь хязгаарлагдмал байна.

Төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд үзүүлэх гол нөлөөлөл нь авто машины хөдөлгүүр дэх түлшний шаталтаас үүсэх хийн хаягдал, авто машины хөдөлгөөнөөс үүсэх тоос тоосонцор, дуу чимээ, доргио, уурхайн ухаш, овоолго зэргээс үүсэх тоос тоосонцор юм. Авто машины хөдөлгүүр дэх түлшний шаталтаас үүсэх хийн хаягдал нь 150-200 м зайд тархах бөгөөд үүнээс цааш хүлцэх агууламжаас бага агууламжтай болно. Авто машины хөдөлгөөнөөс үүсэх тоос тоосонцор 10 м/с салхины хурдны үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дундаж хурд 30 км/цаг, тээврийн хэрэгслийн жин 25 тонн /автосамосвалын өөрийн жин 10 тн, ачааны жин 25 тн/ байна гэж үзвэл  $PM_{10}$  тоосонцорын агууламж 1900 м зайд  $97.2 \text{ мкг/м}^3$  хэмжээтэй байна. 1900 м радиуст тоосонцороос орчны хөрс, ургамлан бүрхэвч, усан орчин, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай юм. Шохойн чулуу олборлолтын үед эгэл хэсгүүд агаарт ялгарах боломж харьцангуй бага юм. Учир нь усан хөргөлтийн системтэй хөрөө, таслагч ашигладаг.

Овоолгоос үүсэх тоосонцорын хамгийн их агууламж нь эх үүсвэрээс 2000 м зайд ажиглагдана. Үүнээс цааш 5000 м зайд тоосонцорын агууламж  $91 \text{ мкг/м}^3$  буюу MNS 4585:2007 стандартын утгаас  $9 \text{ мкг/м}^3$ -аар бага байна. Өөрөөр хэлбэл төслийн олборлолтын талбайгаас 4000 м газар нутгийн хөрс, ургамал, мал, амьтан, хүн ам нөлөөлөлд өртөнө. Энэ орон зайн хүрээгээр нөлөөллийн орон зайн хамгийн их хэмжээ тодорхойлогдоно.

Төслийн талбайн ихэнх хэсэг нь  $15^0$ -аас бага налуутай, гол горхи байхгүй, гуу жалга, харьцангуй бага учир байгалийн үер усны болон хөрсний нуралт гулсалтын аюулд өртөгдөхгүй юм.

4000 м хүрээнд энэхүү байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэх бөгөөд цаашид төслийн үйл ажиллагаанд өөрчлөлт орох нөхцөлд оронзай-цаг хугацаа, үйл ажиллагааны хамрах хүрээнд өөрчлөлт орно. Иймд тухайн үед нь энэхүү байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт өөрчлөлт хийлгэх хэрэгтэй.

*Давхцуулан зураглах аргаар нөлөөлөлд өртөх байгаль, нийгмийн хам бүрдлийг тодорхойлсон дүн*

“Шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах” төслийн ордын ашиглалтын үндсэн процессууд болох үржил шимт өнгөн хөрс хуулалтын ажил, хөрс хуулалтын ажил, Шохойн чулуу олборлолтын ажил, Шохойн чулуу тээвэрлэлтийн ажил, хөрсний гадаад овоолго, тэгшлэлтийн ажил, бэлтгэл ажил зэргээс ургамлан бүрхэвч, хөрсөн бүрхэвч, геологи, геоморфологи зэрэгт үзүүлэх нөлөөллийг тодорхойлохдоо давхцуулан зураглах аргыг ашиглав. Мөн агаар орчинд тархах тоос, тоосонцор болон бусад төрлийн эгэл хэсэг нь хүндийн хүчний нөлөөгөөр газрын гадаргад бууж хөрс, ургамлан бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Агаар бохирдуулагч эх үүсвэрээс ялгарах бохирдуулагч бодисын тархалтыг тооцоолж, бохирдуулагч бодисын тархалтын хилээр нөлөөллийн бүсийг тодорхойлов. Бохирдуулагч бодисын тархалтыг дараах байдлаар тооцоолов. Төслийн үйл

ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийг таамаглаж, учирч болох эрсдэлийг тооцоолж байгаа учир сөрөг нөлөөлөл нь чиг бүрт адил магадлалтай тархана гэж үзсэн.

## 2.2. Болзошгүй нөлөөллийн тоон үнэлгээний нэгтгэл

Нөлөөллийн тоон үнэлгээнд нэгтгэсэн үнэлгээ өгөхдөө Леопольдын матрицын аргыг ашиглав. Леопольдын матрицын аргыг НҮБ-ийн Ази Номхон далайн Эдийн засаг, Нийгмийн Комиссын гаргасан Байгаль орчны үнэлгээ хийх гарын авлагад заагдсан матрицын аргын нэг төрөл юм. Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд (агаар, ус, ургамал, амьтан г.м) нь аливаа төслийн чухам ямар үе шатанд нь нөлөөлөлд илүү их өртөж байгааг үндэс болгон тогтоодог. Экспертийн үнэлгээг ихэнхдээ 1-5 балл гэж үзнэ. Нөлөөлөл хамгийн бага бол 1, хамгийн их бол 5-аар авна.

1. Сөрөг нөлөөгүй буюу маш бага
2. Сөрөг нөлөөлөл бага
3. Сөрөг нөлөөлөл дунд зэрэг
4. Сөрөг нөлөөлөл их
5. Онц уршигтай нөлөөлөл

Байгаль орчны аль нэг бүрэлдэхүүн хэсэг, тодорхой нэг үе шатанд хамаарах дөрвөлжин нүдийг диагональдсан зураас татна. Зураасны дээд талд болзошгүй нөлөөллийн эрчмийг, доод хэсэгт нь нөлөөллийн чухал байдлын зэргийг тус тус тэмдэглэнэ. Дээд талын тоон утга буюу эрчмийг тодорхойлохдоо экспертийн үнэлгээний аргыг ашигласан болно. Доод талын тоон утга буюу нөлөөллийн чухал ач холбогдолтой байдлыг тодорхойлохдоо Байесын критерийн аргыг ашиглав.

Хүснэгт 4. Леопольдын матрицын тоон үнэлгээ буюу нөлөөллийн эрчим

	Олборлолтын үйл ажиллагаа	Боловруулах үйлдвэр	Шимт хөрсний овоолго	Хөрсний овоолго	Дотоод зам	Засварын газар	ШТМ-ын агуулах	Уурхайн тосгон	Автомашинь зогсоол
Агаарын чанар	0	5	0	1	1	0	0	0	1
Газрын гадаргад үзүүлэх нөлөөлөл	3	1	1	1	1	1	0	1	1
Геологийн тогтоц	3	0	0	0	0	0	0	0	0
Глейрхэгхар хүрэн	0	0	0	0	1	1	1	1	1
Хар хүрэн	1	1	1	1	1	1	1	1	1
Эвдрэлд орсон хар хүрэн	0	0	0	0	0	0	0	0	0
Сайргархагхар хүрэн	3	1	1	1	1	0	0	0	0
Алаг өвс-үетэн-шарилжитургамлын бүлгэмдэл	0	0	0	0	1	1	1	1	1
Алаг өвс-үетэнтхуурай хээрийн ургамланбүлгэмдэл	1	1	1	1	1	1	1	1	1
Ургамалгүй	0	0	0	0	0	0	0	0	0
Алаг өвс-агь-үетэнтургамлын бүлгэмдэл	3	1	1	1	1	0	0	0	0
Газрын доорх усны нөөц горимд үзүүлэх нөлөөлөл	2	5	0	0	5	0	0	1	0
Машин техникийн зорчих хөдөлгөөнөөс үүсэх дуу чимээ, газар шорооны ажилтай	3	0	0	0	3	0	0	0	0

	Олборлолтын үйл ажиллагаа	Боловсруулах үйлдвэр	Шимт хөрсний овоолго	Хөрсний овоолго	Дотоод зам	Засварын газар	ШТМ-ын агуулах	Уурхайн тосгон	Автомашинны зогсоол
холбоотойгоор үүсэн бий болох ухсан нүх зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах									
Олборлолтын явцад хөрс хуулалт, газар шорооны ажлын явцад төслийн талбайд тэмдэглэгдсэн мэрэгчид, мөлхөгчид болон шавжийн амьдрах орчин устаж үгүй болох	2	2	2	2	0	0	0	0	0
Уурхай руу татсан өндөр хүчдэлийн шугамандшувуу үргээгч сэнс, толь, хатгуур суурилуулаагүйгээсүүдэн шувууд хүчдэлд цохиулжүхэх	0	0	0	0	0	0	0	4	0
Аливаа нэгэн зүйл устаж, дайжиж алга болсонтой холбоотойгоор экологийнидэштэжээлийн харилцаа холбоо алдагдах дам нөлөөлөл үүсэжболзошгүй.	1	1	1	1	1	1	1	1	1

Экспертийн үнэлгээний нэгдсэн матрицаар төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны хам бүрдлийн өртөгдөх байдал, үйлчлэлийг эрэмбэлэн чухал байдлыг тодорхойлохдоо Байесийнкритерийгашиглав.

$$W_i = \sum_{j=1}^n P_j * R_{ij}$$

Энд:

- $W_i$  – Байесийнкритер
- $P_j$  – Жингийн коэффициент
- $R_{ij}$  – Үнэлгээний эрэмбэлэгдсэн үзүүлэлт

Байесийнкритерийгашиглахын тулд эхлээд тухай үзүүлэлтийн жинг тодорхойлох шаардлагатай байдаг. Жингийн коэффициентийг олохдоо Фишборныүнэлгээ болон нийтлэг тохиолдолд жингийн коэффициент ашигладаг аргууд тус бүрээр нь бодож эдгээр утгуудаас Шеноныэнтропиашиглан жингийн коэффициентийн тооцоолсон утгаас сонголт хийв.

Жингийн коэффициент олохдоо дараах дарааллын дагуу тооцоо хийгддэг байна.

- Экосистемийнтөлөв байдал болон түүнд нөлөөлөх хүчин зүйл хоорондынхамаарлыг харуулсан матриц байгуулах
- Орчны төлөвийн системийн аль нэг төлөв дэх үнэлгээний эрэмбийн утгыг тодорхойлох
- Эрэмбэлсэн цуваа болон мэдээлэх чадварын үнэлгээний хэмжээсийг тооцоолох
- Жингийн коэффициентуудыг тооцоолох
- Тооцоолсон жингийн коэффициентоос сонголт хийх зэрэг болно.

Хүснэгт 5. Жингийн коэффициентийн утга

№	Δ	S	Томьёо-1	Томьёо-2	Томьёо-3

			$P_j = \frac{k * (n - j + 1)}{S}$	$P_j = \frac{\Delta_j}{\sum \Delta_j}$	$P_j = \frac{S_j}{\sum S_j}$
1	5.0	8.0	0.126	0.139	0.078
2	3.0	10.0	0.145	0.083	0.097
3	3.0	3.0	0.077	0.083	0.029
4	1.0	5.0	0.097	0.028	0.049
5	1.0	9.0	0.135	0.028	0.087
6	0.0	0.0	0.068	0.000	0.000
7	3.0	7.0	0.117	0.083	0.068
8	1.0	5.0	0.097	0.028	0.049
9	1.0	9.0	0.135	0.028	0.087
10	0.0	0.0	0.067	0.000	0.000
11	3.0	7.0	0.117	0.083	0.068
12	5.0	13.0	0.155	0.139	0.126
13	3.0	6.0	0.107	0.083	0.058
14	2.0	8.0	0.126	0.056	0.078
15	4.0	4.0	0.087	0.111	0.039
16	1.0	9.0	0.135	0.028	0.087

Дээрх аргаас сонголт хийхдээ Шеноныэнтропыг ашигласан. Энэ нь дараах томъёогоор тооцоологдоно.

$$P_j = - \sum_{j=1}^n P_j * \ln P_j$$

Хүснэгт 6. Шеноны энтропигийн утга

P(1)	P(2)	P(3)	Энтропихамгийн их утга
3.86788	2.48616	2.5775	3.97001

Шеноны энтропигийн утгаас үзэхэд S хэмжээсээс Δ хэмжээс нь мэдээллийн алдагдал багатай болох нь харагдаж байгаа бөгөөд 1-р томъёогоор бодсон жингийн утгыг сонгох нь зүйтэй.

Хүснэгт 7. Нөлөөллийн чухал байдал

	Олборлолтын үйл ажиллагаа	Боловсруулах үйлдвэр	Шимт хөрсний овоолго	Хөрсний овоолго	Дотоод зам	Засварын газар	ШТМ-ын агуулах	Уурхайн тосгон	Автомашини зогсоол
Агаарын чанар	0.00	0.63	0.00	0.13	0.13	0.00	0.00	0.00	0.13
Газрын гадаргад үзүүлэх нөлөөлөл	0.44	0.15	0.15	0.15	0.15	0.15	0.00	0.15	0.15
Геологийн тогтоц	0.23	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Глейрхэгхар хүрэн	0.00	0.00	0.00	0.00	0.10	0.10	0.10	0.10	0.10
Цөлөрхөг хээрийн бор хөрс	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14
Эвдрэлд орсон цөлөрхөг хээрийн бор хөрс	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00

	Олборлолтын үйл ажиллагаа	Боловсруулах үйлдвэр	Шимт хөрсний овоолго	Хөрсний овоолго	Дотоод зам	Засварын газар	ШТМ-ын агуулах	Уурхайн тосгон	Автомашинны зогсоол
Толгодын цөлөрхөг хээрийн нимгэн сайрчулуурхагбор хөрс	0.35	0.12	0.12	0.12	0.12	0.00	0.00	0.00	0.00
Бударгана хөмүүлхялганатбүлгэмдэл	0.00	0.00	0.00	0.00	0.10	0.10	0.10	0.10	0.10
Баглууртаана хялганатбүлгэмдэл	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14
Ургамалгүй	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Баглууртаана хялганатбүлгэмдэл	0.35	0.12	0.12	0.12	0.12	0.00	0.00	0.00	0.00
Газрын доорх усны нөөц горимд үзүүлэх нөлөөлөл	0.31	0.78	0.00	0.00	0.78	0.00	0.00	0.16	0.00
Машин техникийн зорчих хөдөлгөөнөөс үүсэх дуу чимээ, газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэн бий болох ухсан нүх зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах	0.32	0.00	0.00	0.00	0.32	0.00	0.00	0.00	0.00
Олборлолтын явцад хөрс хуулалт, газар шорооны ажлын явцад төслийн талбайд тэмдэглэгдсэн мэрэгчид, мөлхөгчид болон шавжийн амьдрах орчин устаж үгүй болох	0.25	0.25	0.25	0.25	0.00	0.00	0.00	0.00	0.00
Уурхай руу татсан өндөр хүчдэлийн шугамандшувуу үргээгч сэнс, толь, хатгуур суурилуулаагүйгээсүүдэн шувууд хүчдэлд цохиулжүхэх	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.35	0.00
Аливаа нэгэн зүйл устаж, дайжиж алга болсонтой холбоотойгоор экологийнидэштэжээлийн харилцаа холбоо алдагдах дам нөлөөлөл үүсэжболзошгүй.	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14

*Хүснэгт 8. Байесын критер*

	Олборлолтын үйл ажиллагаа	Боловсруулах үйлдвэр	Шимт хөрсний овоолго	Хөрсний овоолго	Дотоод зам	Засварын газар	ШТМ-ын агуулах	Уурхайн тосгон	Автомашинны зогсоол
Байесын критери	2.65	2.44	1.04	1.16	2.20	0.74	0.60	1.25	0.87

Хүснэгт 9. Лейпольдын матриц

	Олборлолтын үйл ажиллагаа		Хөрсний овоолго		Шимт хөрсний овоолго		Буулгах талбай		Дотоод зам		Засварын газар		ШТМ-ын агуулах		Уурхайн тосгон		Автомашини зогсоол	
	Э	С	Э	С	Э	С	Э	С	Э	С	Э	С	Э	С	Э	С	Э	С
Агаарын чанар	0	0.00	5	0.63	0	0.00	1	0.13	1	0.13	0	0.00	0	0.00	0	0.00	1	0.13
Газрын гадаргад үзүүлэх нөлөөлөл	3	0.44	1	0.15	1	0.15	1	0.15	1	0.15	1	0.15	0	0.00	1	0.15	1	0.15
Геологийн тогтоц	3	0.23	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
Глейрхэг хар хүрэн	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	1	0.10	1	0.10	1	0.10	1	0.10	1	0.10
Цөлөрхөг хээрийн бор хөрс	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14
Эвдрэлд орсон цөлөрхөг хээрийн бор хөрс	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
Толгодын цөлөрхөг хээрийн нимгэн сайрчулуурхагбор хөрс	3	0.35	1	0.12	1	0.12	1	0.12	1	0.12	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
Бударгана хөмүүлхялганатбүлгэмдэл	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	1	0.10	1	0.10	1	0.10	1	0.10	1	0.10
Баглууртаана хялганатбүлгэмдэл	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14
Ургамалгүй	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
Баглууртаана хялганатбүлгэмдэл	3	0.35	1	0.12	1	0.12	1	0.12	1	0.12	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
Газрын доорх усны нөөц горимд үзүүлэх нөлөөлөл	2	0.31	5	0.78	0	0.00	0	0.00	5	0.78	0	0.00	0	0.00	1	0.16	0	0.00
Машин техникийн зорчих хөдөлгөөнөөс үүсэх дуу чимээ, газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэн бий болох ухсан нүх зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах	3	0.32	0	0.00	0	0.00	0	0.00	3	0.32	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
Олборлолтын явцад хөрс хуулалт, газар шорооны ажлын явцад төслийн талбайд тэмдэглэгдсэн мэрэгчид, мөлхөгчид болон шавжийн амьдрах орчин устаж үгүй болох	2	0.25	2	0.25	2	0.25	2	0.25	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
Уурхай руу татсан өндөр хүчдэлийн шугаманд шувуу үргээгч сэнс, толь, хатгуур суурилуулаагүйгээс үүдэн шувууд хүчдэлд цохиулжүхэх	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	4	0.35	0	0.00
Аливаа нэгэн зүйл устаж, дайжиж алга болсонтой холбоотойгоор экологийн идэш тэжээлийн харилцаа холбоо алдагдах дам нөлөөлөл үүсэж болзошгүй.	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14



Дээрх хүснэгтээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас газрын доорх усны нөөц, горим, газрын гадаргын хэлбэршил, хар хүрэн хөрс, алаг өвс-үетэнт хуурай хээрийн ургамлан бүлгэмдэл, агаарын чанар, бичил организм зэрэгт үзүүлэх нөлөөлөл их, бусад байгалийн хам бүрдэлд үзүүлэх нөлөөлөл дунд болон бага ангилалд хамаарч байна. Нөлөөлөгч хүчин зүйлээр нь авч үзвэл олборлолтын үйл ажиллагаа хамгийн их нөлөөтэй байна. Олборлолтын үйл ажиллагаа нь байгалийн хам бүрдэл, геологийн тогтоц зэрэг нөлөөлөл үзүүлнэ. Хөрсний овоолго нь агаарын чанарт хамгийн их нөлөөлөл үзүүлэх бөгөөд тоосжилтыг дарах зорилгоор ус ашиглана. Мөн геоморфологийн хэлбэршилд өөрчлөлт оруулах эх үүсвэр юм. Дотоод зам нь агаарын чанар сөрөг нөлөөлөл үзүүлэх эх үүсвэр, хөрсний шугаман элэгдэл, эвдрэлийн эх үүсвэр болно. Мөн тоосжилтыг дарах зорилгоор ус ашиглана. Уурхайн тосгоноос хатуу, шингэн хаягдал ялгарах бөгөөд энэ нь хөрсний бохирдол, агаар дахь нянгийн бохирдлын эх үүсвэр, усны бохирдлын эх үүсвэр болно.

### **2.3.Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим**

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс ил уурхайн аргаар олборлох үед газрын доорх усны нөөц, горим, газрын гадаргын хэлбэршил, хар хүрэн хөрс, алаг өвс-үетэнт хуурай хээрийн ургамлан бүлгэмдэл, агаарын чанар, бичил организм зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна Иймд эдгээр нь голлох нөлөөллийн үнэлгээнд байна. Голлох нөлөөллийг тодруулахад доорх 3 зүйлийг анхаарах шаардлагатай болдог. Үүнд:

- Үйл ажиллагааны бохирдлын түвшинг тодорхойлж, харгалзан үзэх;
- Нөлөөллийн үр дагаврыг бууруулах арга замыг тодорхойлох;
- Төслийн алтернатив хувилбаруудыг зааж өгөх явдал юм;

Шохойн чулууны ил уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, тархалтын хэмжээ болон үр дагавар нь харилцан адилгүй юм. Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс улбаалан байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Уурхайн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт, хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөг талхлагдах, геологийн тогтоц өөрчлөлтөд орох;
- Олборлолтын явцад дуу чимээний улмаас амьтдын орон зайн тархалт өөрчлөгдөх;
- Төслийг барьж байгуулах үед эдэлбэр газар, хөрс эвдрэлд орох, ургамал талхлагдах;
- Шингэн хаягдал замбараагүй хаявал гүний ус болон хөрс, ургамал бохирдох;
- Урьд өмнө нь техногенезэд өртөн хөндөгдөөгүй байсан тус нутгийн газрын гадаргын үндсэн тогтоц, түүний бүрдэл элементүүд болох мезо-микро эрэмбийн хэлбэршлүүд, байгалийн хөгжлийн зүй тогтлоороо олон зуун мянган жилд бүрэлдэн бий болсон байгалийн ландшафтын үндсэн төрх эвдэгдэх;
- Шохойн чулуу олборлох явцад эвдэгдэх талбай багагүй, мөн байгалийн хөгжлийнхөө жамаар тогтсон сэвсгэр хурдсын байрлал, үндсэн чулуулгийн геологийн тогтцыг өөрчилснөөс нягтшилтнь сийрэгжиж, урсгал усны идэж ухах, хуримтлуулах үйл явцад ихээхэн хүчтэй өртөгдөнө;
- Шохойн чулуу олборлох үйл явцад тухайн талбай, түүний орчны эдэлбэр газар, хөрс бүхэлдээ талхлагдан, нөхөн сэргээхэд ихээхэн зардал шаардагдах болно;
- Шохойн чулуу зөөвөрлөх зам болон бусад зам, талбай нь нутгийн агаарын орчин тоосжих эх үүсвэр болон хувирна;
- Эдгээр нь тухайн орчныхоо байгалийн хам бүрдлүүд, ялангуяа агаарын ба газрын чанарт сөргөөр нөлөөлнө. Хуулсан хөрсний овоолго, талхлагдсан газар нь агаарын тоосжилт, газрын эвдрэлийн бичил голомт болон хувирна;

Дээр өгүүлснээс дүгнэлт хийхэд байгаль орчинд сөрөг нөлөөлөл дунд эрчимтэйгээр нөлөөлөх төслийн ангилалд багтах юм. Байгаль орчны бүрдэл хэсгүүдээс нөлөөлөлд өртөх гол бүрдэл хэсэг нь газрын хэвлий болон гадарга, хөрс, ургамал байхаар байна. Иймд төслийн зөвлөмжид дурдсан болон хууль эрхзүйн баримт бичгийг байнга мөрдөн ажиллах хэрэгтэй.

Энэхүү төсөл нь Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт байрлахын хувьд төслийн гол сөрөг нөлөөллийг:

1. Төслийг хэрэгжүүлэхэд бэлтгэх үеийн
2. Төслийн хэрэгжилтийн үеийн гэсэн үндсэн хоёр хэсэгт авч үзэв.

Эхнийх нь богино хугацааных боловч нөхөн сэргээх хугацаа шаардах нөлөөллүүд бөгөөд тэдгээрийн эрч хүч, хамрах хүрээ, хугацаа нь барилгыг барих үеийн удирдлага зохион байгуулалттай холбоотой. Хэрэгжилтийн үеийнх нь төсөл хэрэгжүүлэгчийн өөрсдийн нь үйл ажиллагаатай шууд холбоотой байнгын нөлөөлөл гэж үзэж болно. Голлох нөлөөллийн хамрах хүрээ, эрчмийг нэгтгэж доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 10. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа*

№	Нөлөөллийн голлох хүчин зүйл	Нөлөөлөлд өртөх орчин, объект	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1	Хөрс хуулалт	Хөрс, ургамал	Уурхайн эдэлбэр	Дунд зэрэг	Удаан
		Агаар	Уурхайн орчим	Дунд зэрэг	Богино
		Хөрсний ус	Уурхайн эдэлбэрт	Байхгүй	Богино
2	Хүдэр олборлолт, тээвэрлэх үйл ажиллагаанаас уусгах тоосжилт	Агаар, хөрс, ургамал, геологийн тогтоц	Уурхайн эдэлбэр, орчны нутаг	Дунд зэрэг	Удаан
3	Ажилчдын сууринаас гарах хог хаягдал	Хөрс	Уурхайн эдэлбэрт	Бага зэрэг	Богино
4	Доргио, дуу чимээ	Хүн ам, ан амьтад	Ажиллагсад, ан амьтан	Дунд зэрэг	Богино
5	Бэлтгэх ажлууд	Агаар, хөрс, ургамал	Ажилчдын сууринг байгуулах хэсэг	Дунд зэрэг	Богино

#### **2.4.Төслийг хэрэгжүүлэхэд бэлтгэх үеийн гол нөлөөлөл:**

Төслийн ажил үйлчилгээнээс байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөлөл нь тухайн төслийн ажилчдын суурингын барилга байгууламж барих үе шат болно. Энэ үеийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд:

- Барилгын тоног төхөөрөмж, материал, контейнерзэрэг жин, овор ихтэй зүйлүүдийг нэг газраас нөгөө хэсэгт олон дахин чирчхөрс, ургамлаа сүйтгэхгүй байхаар урьдаас байрлалыг нь зөв сонгож төлөвлөн гүйцэтгэх;
- Автомашины зогсоолыг тохижуулахдаа тохиолдлоор бензин, тос гоожих, асгарах нөхцөлд доош хөрсөнд нэвчихээс хамгаалсан хаалт хийж, хатуу хучилт хийх;
- Барилгын материалыг түр хураах талбайг зөв сонгож байрлуулах;
- Ашиглалтын талбайн хэмжээнд хашаа, хаалт барих;
- Байгуулалтын ажлаас гарсан хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд тээвэрлэн зайлуулах;
- Барилгад хэрэглэгдэх асгарах, гоожих бодисыг салхи, нар борооноос хамгаалсан тусгай байгууламжид хадгалах;

- Барилга байгууламж барих үед болон цаашид ашиглах бие засах газрыг байгаль орчинд хор хөнөөлгүй байдлаар зохицуулах;
- Хөдөлмөр хамгааллын дэглэмийг чанд сахих;
- Химийн бодис асгарснаас хөрс, ургамал, хөрсний ус бохирдох, амьд организм хордох;
- Нунтаг болон цементийн зуурмаг, шохой асгаж, модны зомгол, золтос, үйрдэс, шилний хагархай зэрэг элдэв төрлийн хог хаягдлаар орчныг бохирдуулах;
- Зам жим олширч элэгдэл ихсэх гэх мэтийг анхааралдаа авч ажиллах;

#### **2.5.Төсөл хэрэгжилтийн үеийн байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл**

Төслийн хэрэгжилтээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байгалийн хам бүрдэл тус бүрийн хувьд дэлгэрүүлэн авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Хөрсөн бүрхэвч болон газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл;
- Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл;
- Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл;
- Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл;
- Ажилчдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл;

## ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх,
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх.
- Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж шинээр 300орчим хайлаас болон сухай мод тарих. Мөн сухайн 2000 суулгац суулгаж болон Хайлаасны 2000 үрээр үрсэлгээ хийн дараа дараагийн жилүүдэд ургуулах бэлтгэл ажлыг эхлүүлэх.

Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших “Шохойн чулууны орд”-ыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” баримтлан боловсруулсан болно.

### БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

*Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгтгэл*

№	Ажлын нэр	Зардал /мян.төг/
1	<b>Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>	3,300.0
2	Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн зардал	Энэ онд нөхөн сэргээлт хийгдэхгүй
3	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал	2'500.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөөний төсөв	Зардал төлөвлөөгүй
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний зардал	Зардал төлөвлөөгүй
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	150.0
7	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	300.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	2690,0
9	байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч удирдлага зохион байгуулалтын төсөв	-
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	300.0
<b>Нийт зардал</b>		<b>9'240.0</b>

- Доорх хүснэгтийн 4.12-4.17-д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.4-д тусгагдана.

### 3.1.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

#### 3.1.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүрээлэн буй орчны агаарын чанарын нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Цар тахлын улмаас үүсэх нөхцөл байдлаас хамаарч тус хөтөлбөрийн зарим заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч болзошгүй.

*Хүснэгт 12. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг Нөлөөллийн хамрах хүрээ	Нийт Зардал, төг	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Холбогдох хууль, дүрэм журам, аргачлал, стандарт
1	Ил уурхайн олборлолт болон хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, Замын засвар, арчилгаа хийх хайргаар хучих	Уурхайн талбайн дотоод болон талбайн гадна ашиглагдаж буй замууд	Дотоод үйл ажиллагаа	Уулын инженер	Жилийн турш	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 4585:2007 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага"

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг Нөлөөллийн хамрах хүрээ	Нийт Зардал, төг	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Холбогдох хууль, дүрэм журам, аргачлал, стандарт
2	Дулааны яндангаас бохирдуулагч цацагдаж, агаар бохирдуулах зуухны хий орчныг	Оффисын барилгын халаалтын зуух болон автозасварын газрын халаалтын зуухыг өөрчилж нэгдсэн халаалтын системд холбож 1 зуухаар галлана. Өвлийн улиралд янданг сар бүр хөөлөх	Үйлдвэрийн бүс	Дотоод үйл ажиллагаа	Ерөнхий инженер	Өвлийн улиралд	MNS 5885:2008 "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага" MNS ISO 4227:2002 "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын
3	Хүнд ин механизм засварын газар, машины зогсоол дахь машин, техникүүд агаар орчныг бохирдуулж болзошгүй нөлөөлөл	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмаас ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах. Уурхайн бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, үйлчилгээг тогтмол хийх. Өвлийн улиралд машин техникээс асаах үед гарах утааг бууруулах зорилгоор машин	Уурхайд ашиглагдаж байгаа нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм;	Дотоод үйл ажиллагаа	Механик инженер	Улирал бүр үзлэг хийх. 10 сард багтаан шаардлагатай техникд халуун тогоо суурилуулах	гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг Нөлөөллийн хамрах хүрээ	Нийт Зардал, төг	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Холбогдох хууль, дүрэм журам, аргачлал, стандарт
		техникүүдэд халуун тогоо суурьлуулах					
4	Нүүрс тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх	Үйлдвэрт хэрэглэх нүүрс тээвэрлэгч тээврийн машиныг бүтээлгэтэй байлгах, хяналт тавих	Нүүрс тээвэрлэлтийн зам дагуу	Шаардлага тавих	ХАБЭА-н ажилтан	Жилийн турш	"Агаарын тухай" хууль; MNS 4585:2007 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага"
<b>Нийт</b>				0			

### 3.1.2. УСНЫ НӨӨЦ, ЧАНАРЫН АСУУДАЛ

“Ялгуун Интернэшнл” ХХК-ийн усны менежментийн бодлогын хүрээнд уурхайн бүх үйл ажиллагаанд усыг зөв зохистой хэрэглэх, усыг дахин ашиглах, мөн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах байгаль дахь усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорин ажилладаг. Уурхай зүгээс усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах зорилгын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч, хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 13. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө



№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг Нөлөөллийн хамрах хүрээ	Нийт Зардал, төг	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Холбогдох хууль, дүрэм журам, аргачлал, стандарт
1	Усны менежментийн төлөвлөлтийг зөв оновчтой гаргаагүйгээс уурхай үйл ажилагаанд усыг урт хугацаанд хэмнэлт, дахин ашиглалтгүй ашигласнаар усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учрах	Уурхайн нийт усны хэрэгцээ, эргүүлэн ашиглах усны хэмжээг зорилтод түвшинд байлгах. Мөн усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	Компанийн шинэ ажилчид, болон зочид	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭАБО-н мэргэжилтэн	Тухай бүр	“Усны тухай” хууль, “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998, Компанийн дотоод журам
2	Зэрлэг ан амьтан уух усгүй болох.	Усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоох, хашаажуулж цэвэрлэх	Сүмийн булгийн ойр орчмын мал, зэрлэг ан амьтан	1.000,000	Уурхайн дарга	10сард дуусгах	А-230/127 Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам Усны тухай хууль: Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998.
3	Ундны усны чанар алдагдах	Уурхайн ундны усны худгийг эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож хашаажуулж тэмдэгжүүлнэ.	Уурхайн худаг	500,000	БОхариуцсан мэргэжилтэн	8сар	
<b>Нийт</b>				1.800.000			

Цар тахлын улмаас үүсэх нөхцөл байдлаас хамаарч тус хөтөлбөрийн зарим заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч болзошгүй.

### 3.1.3. ХӨРСӨН БҮРХЭВЧИД УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 14. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг Нөлөөллийн хамрах хүрээ	Нийт Зардал, төг	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Холбогдох хууль, дүрэм журам, аргачлал, стандарт
1	Хөрс орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд шийдвэр-лэнэ	Дотоод үйл ажиллагаа	Компани удирдлага, Ерөнхий инженер	Жилийн турш	Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ MNS 5973:2009
2		Кемпийн хашаан дотор хөрсний элэгдлийг бууруулах зориулалтаар явган хүний замын хажуу талаар ногоон зүлэгжүүлэх, мод тарих	Уурхайн кемпийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	300,000	Кемп менежер, БО-н мэргэжилтэн	6,7,8,9 сард	
3	Хөрс, газрын доорхи ус, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах	Ариун цэврийн байгууламж, бохир усны цооног, хог хаягдлын цэг нийт 3 цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Уурхайн үйлдвэрийн хэсэг болон кемпийн хэсэг	Дотоод үйл ажиллагаа	Ерөнхий инженер	Кемпийн хэсэгт сард 1 удаа. Үйлдвэрийн хэсэгт 2сард 1 удаа	
4	Цөлжилт, хуурайшилт	Шинээр 300 мод тарих, дараа дараагийн жилүүдэд тарих 2000 орчим сухайн үрсэлгээ хийх, 2000 хайлаас үрээр тарих	Уурхайн кемпийн хашаанд	1,000,000	БО-н ажилтан, кемпийн ажилтан	Жилийн турш	Ерөнхийлөгчийн 2021оны 10сарын 04ний 58-р зарлиг Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн.
Нийт				1300,000			

### 3.1.4 БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛД УЧРУУЛАХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 15. Биологийн төрөл зүйлд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг Нөлөөллийн хамрах хүрээ	Нийт Зардал, төг	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Холбогдох хууль, дүрэм журам, аргачлал, стандарт
1	Амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах, хууль бус агнуур, шувууд цахилгаанд цохиулах, цахилгааны утас мөргөх гэх мэтээр үхэж, хорогдох эрсдэлтэй	Цахилгаан дамжуулах шугаманд суурилуулсан шувуу үргээгчийг шинэчлэх (20ш)	Хамрын хийдээс уурхай хүртэлх цахилгаан дамжуулах шугам	200,000	Цахилгааны инженер	8сард цахилгааны шугамд урсгал засвар үйлчилгээ хийх	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2		Уурхайн нийт ажилчид болон тээврийн жолооч нарт зэрлэг ан амьтан нүүдэллэх, ороо орох бэлчээрлэх тээврийн замыг хөндлөн гарах үеэр зам тавьж өгөх зэрлэг ан амьтныг хайрлан хамгаалах талаар сургалт орох	Уурхайн нийт ажилтан	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА-н ажилтан		
3	Ган гачигдал болж ан амьтан уух усгүй болох.	Зэрлэг ан амьтанд зориулж Сүмийн булгийг хамгаалалтын бүс тогтоож ус урсах хэсэгт үүсмэл цөөрөм барьж	Зэрлэг ан амьтан				
Нийт				200,000			

Цар тахлын улмаас үүсэх нөхцөл байдлаас хамаарч тус хөтөлбөрийн зарим заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч болзошгүй.

### 3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Ил уурхайн ашиглалтын 2022оны төлөвлөлтөөр хөрс хуулалт, шохойн чулуу олборлолт хийгдэх явцад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх хугацаа хийх болоогүй байна.

### 3.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уул уурхайн үйл ажиллагааны дараа нөхөн сэргээлтийг маш сайн хийсэн ч нөлөөлөл ямар нэг хэлбэрээр үлддэг. Тэрхүү нөлөөллийг бууруулах олон арга байдгийн нэг нь дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа юм. Иймд бид дүйцүүлэн хамгаалах хэлбэрээр Өргөн сумын Газрын алба, Өргөн сумын Засаг даргын тамгын газартай хамтарч Хавцгай нэртэй газар барилгын хог хаягдал хаягдсан орхигдсон газарыг дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийх замаар төлөвлөж байна.

Хүснэгт 16. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө


№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт Зардал, төг	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Холбогдох хууль, дүрэм журам, аргачлал, стандарт
1	Өргөн сумын нутагт эзэнгүй орхигдсон эвдэрсэн нүх, овоолсон шороог аюулгүй байдлыг хангах зорилгоор тэгшилж техникийн нөхөн сэргээлт хийж, орон нутагт актаар хүлээлгэн өгөх	Хүн, мал, зэрлэг ан амьтанд ээлтэй амьдрах орчинг аюулгүй болгох	Өргөн сумын иргэд болон мал, мал бүхий иргэд, зэрлэг ан амьтан, биологийн олон янз байдал	2.500.000	Уурхайн ИТА	9 сард	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, Байгал орчны нарийвчилсан үнэлгээ
Нийт				2.500.000			

### Дорноговь аймгийн Өргөн сум

Нэгж талбарын дугаар: 4403009060 Эрхийн төрөл: эзэмших

Регистрийн дугаар: 9027394 Хуулийн этгээдийн нэр: Дорноговь аймгийн Өргөн сумын засаг даргын тамгын газар ЗДТГ-ын дарга: О.Цасанцэцэг

<b>ХАЯГ:</b> Аймаг/Хот: Дорноговь Гудамж: Тоот:	Сум/Дүүрэг: Өргөн	Баг/Хороо: 1-р баг	Кадастрын муж: 0030
--	-------------------	--------------------	---------------------



Зургийн масштаб = 1:1543 (1 сантиметрт 15.43 метр багтана)

Хэвлэсэн огноо: 2022-06-15

#### Орчны тойм

Координатын систем:

WGS84/UTM 49N

EPSG: 32649



Нэгж талбар

Масштаб = 1: 13542

№	X	Y	Урт
1	477625.90	4948920.23	118.05
2	477658.08	4948806.88	269.49
3	477911.74	4948898.57	91.74
4	477881.66	4948985.07	263.57

Барилга

№	X	Y	Урт	Дугаар	Талбай
---	---	---	-----	--------	--------

Талбайн хэмжээ: 27888 квадрат метр



Энэхүү кадастрын зураг нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

Цар тахлын улмаас үүсэх нөхцөл байдлаас хамаарч тус хөтөлбөрийн зарим заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч болзошгүй.

### 3.4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

